



“РСЦ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Н.БАТЦЭНГЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.13 № 3/413
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “РСЦ” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгад аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“РСЦ” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“РСЦ” ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “РСЦ” ХХК-ийн санхүүгийн тайлан, түүний тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"РСЦ" ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



"РСЦ" ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас: 261885
Цахим хаяг:
zolzayan@audit.gov.mn

Аудитор: Б.Баярмаа
Утас: 260512
Цахим хаяг:
bayarmaab@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Засгийн газрын IV
байр, Бага тойруу-6, УБ-46
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2017 оны 02 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Шилэн дансны мэдээлэл
- 10.Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
- 11.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
- 12.Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
13. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
14. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
15. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
16. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
17. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
18. Зөвлөмж
19. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "РСЦ" ХХК -ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2017/82/14-ТӨҮГ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

"РСЦ" ХХК -ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

"РСЦ" ХХК -ийн удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь хөндлөнгийн аудитын байгууллагын үүрэг юм.

"РСЦ"ХХК -ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 15-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн "Нью диил Аудит" ХХК-ийн захирал, аудитор Э.Эрдэнэбат ахалж, аудитор Ж.Лхагвасүрэн, аудиторын туслах Э.Эрхэмбаяр нар гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-8/

"РСЦ" ХХК -ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 6-нд "Нью диил Аудит" ХХК-д албан тоотоор ирүүлсэн байна.

"Нью диил Аудит" ХХК нь аудитыг 2017 оны 2 дугаар сарын 15-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 27-нд "РСЦ" ХХК -ийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

"РСЦ" ХХК -ийн удирдлага нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго,үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “ Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн дагуу өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж байгаа ТӨААТҮГ юм. "РСЦ" ХХК нь орон нутаг газар зүйн байршлаар Орхон аймгийн "Говил" багийн нутаг дэвсгэрт байрладаг, Улаанбаатар хотоос 400 км-ийн зайд алслагдсан. "РСЦ" ХХК нь барилга угсралтын, засал чимэглэлийн, металл хийцийн гэсэн 3 үйлдвэрлэлийн үндсэн хэсэгтэй, мөн мужаан цех, бетон зуурмагийн узель, вакум цонхны үйлдвэрлэл бүхий байгууламжтай, барилгын иж бүрэн ажилбарыг гүйцэтгэх чадвартай 240-өөд ажиллагсдыг байнгын ажлын байраар хангаж ажиллаж байна. "РСЦ" ХХК нь Орхон аймгийн ХХБ (407142149),Төрийн банк (130000325236) банктай харьцдаг.

"РСЦ" ХХК нь Компанийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа амжилттай удирдан зохион байгуулан ажиллаж байна.

"РСЦ" ХХК -ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар "РСЦ" ХХК -ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого зардлын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-1/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 9-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/ Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг НББ-ийн тухай хууль, НББОУС, СТОУС-тай нийцүүлэн боловсруулан мөрдөж ажиллаж байна.

"РСЦ" ХХК -ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

"РСЦ" ХХК -ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг "ЕРА" санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. "ЕРА" санхүүгийн програм нь "Эрдэнэт Үйлдвэр" ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагддаг сүлжээгээр бүрэн холбогдсон програм байна.

Материаллаг байдал:

Төлөвлөлтийн үе шатанд материаллагийн түвшинг тогтоохдоо урьдчилсан байдлаар борлуулалтын орлогоос нь 2%-иар бодож 177,3 сая төгрөгөөр тооцож байсан. Харин гүйцэтгэлийн үе шатанд 2016 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн цэвэр борлуулалтын орлогын дүнгээс нь 1%-иар тооцож 142,5 сая төгрөгөөр шинэчлэн тогтооход материаллагийн түвшин 34,7 сая төгрөгөөр буурсан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. "РСЦ" ХХК нь дотоод хяналтын системээ сайжруулахын тулд хангамжийн алба, санхүүгийн албаны ажилтнууд хамтарч ажилласнаар бараа материалыг хүлээн авах, бүртгэх, зарцуулалтад тавих хяналт сайжирсан, мөн байгууллагын "Өмч хамгаалах зөвлөл"-өөс хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажиллаж хэвшсэн байна.

"РСЦ" ХХК -ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны 01-р сарын 05-ний өдрийн ТУЗ-ийн шийдвэрээр баталсан 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн бизнес төлөвлөгөөний дагуу ажиллаж гүйцэтгэлийг гаргаж ажилладаг байна. Энэ төлөвлөгөөгөөр нийт үйлдвэрлэлт, борлуулалтын дүнг сар, улирлын хуваариар гаргаж биелэлтийг тооцож гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

"РСЦ" ХХК нь 2016 онд 14276,1 сая төгрөгийн ажил үйлчилгээ үзүүлж, гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс 203,2 сая төгрөгийн орлого олсноос,

борлуулсан бүтээгдэхүүний өртөг 12629,0 сая төгрөг, удирдлагын зардал 1015,8 сая төгрөг, бусад зардал 663,1 сая төгрөгийн зардлыг тус тус гаргаж 130,9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

"РСЦ" ХХК -ийн 2016 онд үндсэн үйлдвэрлэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт 1,0%-иар тасарсан байна. Үүний шалтгаан "Эрдэнэт үйлдвэр" ХХК-иас хэрэгжүүлсэн хэмнэлтийн бодлогоор үйлдвэрлэлийн барилга засварын ажлыг багасгаж тайлант хугацааны 1-р улиралд сул зогсолт хийсэн явдал юм байна. Тайлант хугацааны нийт үйлдвэрлэлийн орлого 14276,1 сая төгрөг болж өнгөрсөн онтой харьцуулахад 2566,1 сая төгрөг буюу 16,2 %-иар буурсан байна. Балансын нийт ашиг 130,9 сая төгрөг байгаа нь өнгөрсөн 2015 оны мөн үетэй харьцуулахад 871,0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд компанийн нийт орлогын 78,4%-ийг барилга угсралт, засварын хэсэг, 10,4 %-ийг засвар монтажийн хэсэг, 11,2 %-ийг туслах үйлдвэрлэлийн орлого тус тус эзэлж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгууллагын **erdenetmc.mn** вэб хуудсанд нээсэн "РСЦ" сайтад төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр 12 удаа, хангамжийн хэлтсээс худалдан авалт, тендерийн холбогдолтой мэдээллийг 6 удаа үнэн зөв, бодитой, тогтмол байршуулж хэвшсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал:

Аудитын гүйцэтгэлийн ажлын явцад хэрэгжүүлсэн 5 сорилоос 4 сорил нь холбогдох батламж мэдэгдлүүдийг хангаж үлдэх 1 сорил нь зарим батламж мэдэгдлүүдийг хангахгүй байв.

Бараа материалын няравын ажлын байрны тодорхойлтонд "Шууд захирагдах албан тушаалтан" нь Хангамжийн ахлах инженер, "Шууд бус захирагдах албан тушаалтан" нь Ерөнхий нягтлан бодогч гэж заасан нь Сангийн сайдын 2000 оны 04-дүгээр саырн 28-ний өдрийн 69 тоот тушаалаар батлагдсан "Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм" –ийн 8-д "Эд хариуцагч нь өмч хөрөнгийг хамгаалах, бүртгэж, тооцоолох, хэмнэлттэй зарцуулах, ашиглалтанд хяналт байнга тавьж, өөрийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлж, бүртгэл тооцооны ажлын анхны мэдэгдэхүүн, нягтлан бодох бүртгэлийн талаарх зохих мэдлэгийг заавал, эзэмшин байгууллагын захиргаа болон санхүү, бүртгэлийн хэлтэс /ерөнхий нягтлан бодогч, хариуцсан нягтлан бодогч/-ийн шууд удирдлагын дор ажлаа явуулж байна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

"РСЦ" ХХК -ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, хөрөнгийн элэгдэл, бусад орлого, авлага, өглөгийн дансуудад ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны сорилоор: Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 27858,5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл касс- 0,3 сая төгрөг, харилцах дансанд 1047,7 сая төгрөг байгаа нь харилцах дансны банкны үлдэгдлийн баталгаа, мөнгөн хөрөнгийн журналын дүнтэй тохирч байна.

Үндсэн хөрөнгийн дансны сорилоор: Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 689,2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6998,3 сая төгрөг байгаа нь хөрөнгийн тооллогын бүртгэл, үндсэн хөрөнгийн журналын үлдэгдэлтэй тохирч байна. Тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 267,0 сая төгрөг (хашаа-13,9 сая, howo fawj6-25 тн-120,0 сая, тавилга эд хогшил-2,3 сая, тоног төхөөрөмж-130,8)-ийн хөрөнгө худалдан авч 160,9 сая төгрөгийн хөрөнгийг акталж, шилжүүлсэн байна. Оны эхний хуримтлагдсан элэгдэл 3714,7 сая төгрөг байсан бол тайлант жилд 424,8 сая төгрөгийн элэгдэл байгуулж хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл 4139,5 сая төгрөг болж цэвэр хөрөнгийн 2858,8 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Цэвэр хөрөнгийн дүн нь санхүүгийн байдлын тайланд, хөрөнгийн орлого нь мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө олж бэлтгэх зардлаар, тайланд онд байгуулсан элэгдэл нь санхүүгийн үр дүнгийн тайланд үнэн зөв тайлагнагдсан байна. Нэмэгдсэн хасагдсан хөрөнгөнүүд нь компанийн ТУЗ-ийн шийдвэрээр нотлогдож байна.

Бараа материалын дансны сорилоор: Бараа материалын дансны эхний үлдэгдэл 763,8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1355,1 сая төгрөг байгаа нь бараа материалын журналын үлдэгдэл, тооллогын бүртгэлтэй тохирч байна. Тайлант онд бараа материалын үлдэгдэл 628,3 сая төгрөгөөр өссөн нь "Эрдэнэт" спорт цогцолборын барилгын дээврийн засварын ажлын 404,6 сая төгрөгийн барилгын материал, 160,1 сая төгрөгийн хотын орон сууцны барилгуудын фасадын ажлын материал, 63,6 сая төгрөгийн "Бөхийн өргөө" -ний барилгын ажлын материал татан авалттай тус тус холбоотой байна.

Орлогын дансны сорилоор: Үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого 14249,3 сая төгрөгөөр орлогын дэлгэрэнгүй тайланд тайлагнасан нь НӨАТ-ын цахим тайлангийн цэвэр борлуулалтын дүнтэй тохирч байна.

Урьдчилж орсон орлого дансны сорилоор: Аймгийн ЗДТГ-аас орон сууцны байрнуудын фасад будах материалын болох 100,0 сая төгрөгийн ажил хийгдээгүй тул үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Авлагын дансны сорилоор: Оны эхний үлдэгдэл дансны авлага 1377,4 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэрийн авлага 5674,6 сая төгрөг бүгд 7052,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 3716,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 3335,6 сая төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын 1763,5 сая төгрөг буюу 47,5%-ийг

Эрдэнэт үйлдвэрийн авлага эзэлж байна. Тус компанийн дансны авлага нь 3 компанитай холбоотой байдаг. Үүнээс Сэцэд (3,7 сая),-ийн авлага шүүхийн шатанд хянагдаж байгаа, Эм Жи Би Ай(49,7 сая)-ийн авлага ШШГА-аар төлөгдөж байгаа, Монгол дайван компанийн 1899,5 сая төгрөгийн авлага нь Эрдэнэт үйлдвэртэй тооцохоор тохирсон. Дансны авлага болон Эрдэнэт үйлдвэрийн авлага дансны үлдэгдлүүд нь тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Өглөгийн дансны сорилоор: Оны эхний үлдэгдэл 2785,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 697,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 2087,6 сая төгрөгөөр буурсан байна. Барилгын ажил эхлэхээр Эрдэнэт үйлдвэрээс авлагаа тооцон авч, өмнөх оны ажил гүйцэтгэсэн компанийн өглөгийг барагдуулсан. Тайлант оны өглөгийн үлдэгдэл фасадын ажил гүйцэтгэсэн 26 компанийн барьцаа өглөг байна. Өглөгийн үлдэгдэл нь тооцоо нийлсэн актаар баталгаажсан, өглөгийн журналын үлдэгдэлтэй тохирч байгаа нь аудитын оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаж байна.

Хуримтлагдсан ашиг дансны сорилоор: ХА дансны эхний үлдэгдэл 2391,0 сая төгрөг, тайлант онд ТУЗ-ийн шийдвэрээр 300,6 сая төгрөгийн ногдол ашгийг тооцож, 130,9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж 2221,4 сая төгрөгийн хуримтлагдсан ашгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Энэ нь орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан ашгийн дүнтэй тохирч байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад дотоод хяналттай холбоотой материаллаг бус дараах алдаа илэрсэн. Үүнд:

Бараа материалын нярав нь ажлын байрны тодорхойлолтод зааснаар ажил үүргийн хувьд Хангамжийн албаны ахлах инженерийн шууд удирдлаганд ажиллах нь байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг сулруулах, бүртгэлээр тавих хяналт алдагдах үндсэн нөхцөл болно.

Шийдвэрлэсэн:

- Бараа материалын няравын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн Сангийн сайдын 2000 оны 04-дүгээр сарын 28-ний өдрийн 69 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 2016 оны санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

"РСЦ" ХХК -ийн хувьд анхаарал татахуйц асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

"РСЦ" ХХК -ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналттай холбоотой зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч ажиллалаа.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг "Ньюдиил Аудит" ХХК хийж гүйцэтгэсэн байна. Аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 100%-ийн биелэлттэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"РСЦ" ХХК -ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

"РСЦ" ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Дотоод хяналт.....3

2017 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ""РСЦ" ХХК -ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг. ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллагаас гаргасан энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан "РСЦ" ХХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Дотоод хяналт**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

"РСЦ" ХХК-ийн бараа материал хариуцсан няравын ажлын байрны тодорхойлтонд "Шууд захирагдах албан тушаалтан" нь Хангамжийн ахлах инженер, "Шууд бус захирагдах албан тушаалтан" нь Ерөнхий нягтлан бодогч гэж заасан нь Сангийн сайдын 2000 оны 04-дүгээр саырн 28-ний өдрийн 69 тоот тушаалаар батлагдсан "Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм" –ийн 8-д "Эд хариуцагч нь өмч хөрөнгийг хамгаалах, бүртгэж, тооцоолох, хэмнэлттэй зарцуулах, ашиглалтанд хяналт байнга тавьж, өөрийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлж, бүртгэл тооцооны ажлын анхны мэдэгдэхүүн, нягтлан бодох бүртгэлийн талаарх зохих мэдлэгийг заавал, эзэмшин байгууллагын захиргаа болон санхүү, бүртгэлийн хэлтэс /ерөнхий нягтлан бодогч, хариуцсан нягтлан бодогч/-ийн шууд удирдлагын дор ажлаа явуулж байна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалын няравын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн Сангийн сайдын 2000 оны 04-дүгээр саырн 28-ний өдрийн 69 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Бараа материалын ашиглалт үүсэх, бүртгэлээр тавих хяналт алдагдана

Үйлчлүүлэгчийн хариу

Ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж ажиллана

АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

"РСЦ" ХХК

2016 оны 12 - р сарын 31 өдөр

(аж ахуйн нэгжийн нэр)

төгрөг - өөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	ҮЛДЭГДЭЛ		ЗАЛРУУЛГА		АУДИТЛАСАН	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ						
1.1	Эргэлтийн хөрөнгө						
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	215,326,005.00	1,047,967,491.00	-	-	215,326,005.00	1,047,967,491.00
1.1.2	Дансны авлага	1,377,382,308.00	1,952,886,161.00	-	-	1,377,382,308.00	1,952,886,161.00
1.1.3	Татвар, НДШ - ын авлага	323,123,918.00	148,530,335.00	-	-	323,123,918.00	148,530,335.00
1.1.4	Бусад авлага	5,674,641,636.00	1,763,497,362.00	-	-	5,674,641,636.00	1,763,497,362.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө			-	-		
1.1.6	Бараа материал	763,795,805.00	1,355,059,813.00	-	-	763,795,805.00	1,355,059,813.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо			-	-		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө			-	-		
1.1.9	Борлуулалтын зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)			-	-		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,354,269,672.00	6,267,941,162.00	-	-	8,354,269,672.00	6,267,941,162.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө			-	-		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,177,451,979.00	2,858,791,798.00	-	-	3,177,451,979.00	2,858,791,798.00
1.2.2	Биет бус хөрөнгө			-	-		
1.2.3	Биологийн хөрөнгө			-	-		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт			-	-		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			-	-		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө			-	-		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			-	-		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө			-	-		
1.2.9	Элэгдэл			-	-		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,177,451,979.00	2,858,791,798.00	-	-	3,177,451,979.00	2,858,791,798.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,531,721,651.00	9,126,732,960.00	-	-	11,531,721,651.00	9,126,732,960.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			-	-		
2.1	Өр төлбөр			-	-		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр			-	-		
2.1.1.1	Дансны өглөг	2,785,495,908.00	697,903,221.00	-	-	2,785,495,908.00	697,903,221.00
2.1.1.2	Цалингийн өглөг	236,288,821.00	292,766,439.00	-	-	236,288,821.00	292,766,439.00
2.1.1.3	Татварын өр	333,646,208.00	24,714,414.00	-	-	333,646,208.00	24,714,414.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг	84,625,386.00	51,351,165.00	-	-	84,625,386.00	51,351,165.00
2.1.1.5	Богино хугацаат зээл			-	-		
2.1.1.6	Хүүний өглөг			-	-		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг			-	-		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		100,088,994.00	-	-		100,088,994.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/			-	-		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр			-	-		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө			-	-		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,440,056,323.00	1,166,824,233.00	-	-	3,440,056,323.00	1,166,824,233.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр			-	-		
2.1.2.1	Урт хугацаат зээл			-	-		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/			-	-		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		37,900,896.00	-	-		37,900,896.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр			-	-		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	37,900,896.00	-	-	-	37,900,896.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,440,056,323.00	1,204,725,129.00	-	-	3,440,056,323.00	1,204,725,129.00
2.3	Эздийн өмч			-	-		
2.3.1	Өмч: - Төрийн	5,593,680,176.00	5,593,680,176.00	-	-	5,593,680,176.00	5,593,680,176.00
2.3.2	- Хувийн			-	-		
2.3.3	- Хувьцаат			-	-		
2.3.4	Халаасны хувьцаа			-	-		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	106,634,052.00	106,634,052.00	-	-	106,634,052.00	106,634,052.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	308,492.00	308,492.00	-	-	308,492.00	308,492.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц			-	-		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг			-	-		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,391,042,608.00	2,221,385,111.00	-	-	2,391,042,608.00	2,221,385,111.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,091,665,328.00	7,922,007,831.00	-	-	8,091,665,328.00	7,922,007,831.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	11,531,721,651.00	9,126,732,960.00	-	-	11,531,721,651.00	9,126,732,960.00

АУДИТЛАСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

"РСЦ" ХХК

(аж ахуйн нэгжийн нэр)

2016 оны 12- р сарын 31

төгрөг - өөр

Мөр ийн дуга ар	Үзүүлэлт	ӨМНӨХ ОНЫ	ТАЙЛАНТ ОНЫ	ЗАЛРУУЛГА	АУДИТЛАСАН
1	Борлуулалтын орлого (цэвэр)	16,817,507,022.00	14,249,317,796.00	-	14,249,317,796.00
2	Борлуулалтын өртөг	13,859,677,187.00	12,629,016,632.00	-	12,629,016,632.00
3	Нийт ашиг (алдагдал)	2,957,829,835.00	1,620,301,164.00	-	1,620,301,164.00
4	Түрээсийн орлого			-	
5	Хүүний орлого	11,269,008.00	25,930,215.00	-	25,930,215.00
6	Ногдол ашгийн орлого			-	
7	Эрхийн шимтгэлийн орлого			-	
8	Бусад орлого	12,497,728.00	833,932.00	-	833,932.00
9	Борлуулалт, маркетингийн зардал			-	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	990,141,507.00	1,015,821,401.00	-	1,015,821,401.00
11	Санхүүгийн зардал			-	
12	Бусад зардал	837,908,364.00	663,102,777.00	-	663,102,777.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	- 890,626.00	203,258,811.00	-	203,258,811.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			-	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			-	
16	ХО борлуулсанаас үүссэн олз (гарз)			-	
17	Бусад ашиг (алдагдал)			-	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,152,656,074.00	171,399,944.00	-	171,399,944.00
19	Орлогын татварын зардал	150,777,659.00	40,493,917.00	-	40,493,917.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,001,878,415.00	130,906,027.00	-	130,906,027.00
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			-	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,001,878,415.00	130,906,027.00	-	130,906,027.00
23	Бусад дэлгэрэнгүй орлого			-	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			-	
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-	
	Бусад олз (гарз)			-	
24	Орлогын нийт дүн			-	
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			-	

АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"РСЦ" ХХК

(аж ахуйн нэгжийн нэр)

2016 оны 12 - р сарын 31 өдөр

төгрөг - өөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	5,593,680,176.00		106,634,052.00	308,492.00			2,391,042,608.00	8,091,665,328.00
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
3	Залруулсан үлдэгдэл								-
4	Тайлан үеийн цэвэр ашиг (алдагдал)							130,906,027.00	130,906,027.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг							300,563,524.00	300,563,524.00
8	Дахин үнэлгээний дүн								-
9	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,593,680,176.00	-	106,634,052.00	308,492.00	-	-	2,221,385,111.00	7,922,007,831.00

АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

1	2015 оны 12 - р сарын 31 - ний үлдэгдэл	5,593,680,176.00		106,634,052.00	308,492.00		-	2,391,042,608.00	8,091,665,328.00
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
3	Залруулсан үлдэгдэл								-
4	Тайлан үеийн цэвэр ашиг (алдагдал)							130,906,027.00	130,906,027.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг							300,563,524.00	300,563,524.00
8	Дахин үнэлгээний дүн								-
9	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,593,680,176.00	-	106,634,052.00	308,492.00	-	-	2,221,385,111.00	7,922,007,831.00
	Эхний үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
	Эцсийн үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-
	Залруулга	-	-	-	-	-	-	-	-

АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"РСЦ" ХХК

(аж ахуйн нэгжийн нэр)

төгрөг - өөр

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОНЫ	ТАЙЛАНТ ОНЫ	АУДИТЛАСАН
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	237,514,510.00	869,512,419.00	869,512,419.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,703,988,981.00	18,285,498,703.00	18,285,498,703.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	13,842,938,204.00	17,668,637,084.00	17,668,637,084.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого			
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	33,353,621.00	54,008,945.00	54,008,945.00
	Буцаан авсан албан татвар			
	Татаас, санхүүжилтийн орлого	827,697,156.00	562,852,674.00	562,852,674.00
	Бусад мөнгөн орлого			
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,466,474,471.00	17,415,986,284.00	17,415,986,284.00
	Ажиллагчидад төлсөн	5,073,323,659.00	3,801,061,480.00	3,801,061,480.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,120,898,440.00	965,046,261.00	965,046,261.00
	Бараа материал худалдаж авахад төлсөн	6,417,533,397.00	11,409,136,155.00	11,409,136,155.00
	Ашиглалтын зардалд төлсөн			
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	20,917,900.00	83,025,900.00	83,025,900.00
	Хүүний төлбөрт төлсөн			
	Татварын байгууллагад төлсөн	1,527,825,319.00	1,099,553,901.00	1,099,553,901.00
	Даатгалын төлбөрт төлсөн	10,975,756.00	9,877,587.00	9,877,587.00
	Бусад мөнгөн зарлага	295,000,000.00	48,285,000.00	48,285,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	237,514,510.00	869,512,419.00	869,512,419.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,730,372.00	26,566,579.00	26,566,579.00
	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	12,461,364.00	636,364.00	636,364.00
	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого			
	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого			
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт			
	Хүлээн авсан хүүний орлого	11,269,008.00	25,930,215.00	25,930,215.00
	Хүлээн авсан ногдол ашиг			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	208,233,369.00	267,052,834.00	267,052,834.00
	Үндсэн хөрөнгө олз эзэмшихэд төлсөн	208,233,369.00	267,052,834.00	267,052,834.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн			
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа			
2.3	ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(184,502,997.00)	(240,486,255.00)	(240,486,255.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,049,429.00)	203,615,322.00	203,615,322.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		203,615,322.00	203,615,322.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
	Төрөл бүрийн хандив			
	Валютын ханшийн зөрүү		203,615,322.00	203,615,322.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,049,429.00	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө			
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн			
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн			
	Төлсөн ногдол ашиг			
	Төрөл бүрийн хандив			
	Валютын ханшийн зөрүү	1,049,429.00		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,049,429.00)	203,615,322.00	203,615,322.00
4	Бүх цэвэр мөнгөн дүн	51,962,084.00	832,641,486.00	832,641,486.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	163,363,921.00	215,326,005.00	215,326,005.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,326,005.00	1,047,967,491.00	1,047,967,491.00